**ДУНДГОВЬ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2021 оны 06 сарын 28 өдөр Дугаар А/143 Мандалговь

"Инел хан" ХХК-тай гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/240 тоот захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "Хөдөөгийн хүн амд сүрьеэ өвчний илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог хийх төсөл", "Хөдөөгийн хүн амд бэлгийн замаар дамжих халдварын илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог хийх төсөл" ажлын батлагдсан зардлаас Короновирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор "Дэлгэх эмнэлэгт шаардлагатай хамгаалах хувцас хэрэглэл, тоног төхөөрөмж нийлүүлэх" ажлыг "Инел хан" ХХК-тай 20,000,000 (хорин сая) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2.Гэрээнд заасан хугацаанд Короновирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор дэлгэх эмнэлэгт шаардлагатай хамгаалах хувцас хэрэглэл, тоног төхөөрөмж нийлүүлэхийг "Инел хан" ХХК-ний захирал (С.Нарангарав)-т үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Эрүүл мэндийн газрын дарга (Б.Алтантөгс), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ

4862109?7